



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 08

Улаанбаатар

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дугаар зүйлийн “к” заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Тахько (ХК) компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Л.Буянбат)-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 09

Улаанбаатар

### АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1, 94.16 дахь заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 8.1.1, 8.1.10 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Тахько (ХК) компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн “Мүүрь Аудит” (ХХ) компанийн тайлан дүгнэлтийг компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Л.Буянбат)-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ